



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/405

Булган сум

Газрын зөрчил болон хилийн цэсийн маргаантай асуудал, иргэний бүртгэлийн зөрчил шийдвэрлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.17, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн сумдад гарч байгаа газрын зөрчил болон хилийн цэсийн маргаантай асуудал, иргэний бүртгэлийн зөрчил шийдвэрлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Д.Наранбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
Ж.Ганболд (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

А.Ганбагана (Сэлэнгэ сумын Засаг дарга)

С.Ичинхорлоо (Хангал сумын Засаг дарга)

П.Отгондаваа (Хялганат тосгоны захирагч)

Нарийн бичгийн дарга: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн, хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Сумдад гарч байгаа газрын зөрчил болон хилийн цэсийн маргаан, иргэний бүртгэлийн зөрчлийн асуудлыг газар дээр нь очиж танилцан холбогдох хууль журмын хүрээнд шийдвэрлэхийг ажлын хэсэг (Д.Наранбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010564